In 1995-1997, the State Great Khural amended the “Law of Mongolia on Administrative and Territorial Units and Their Governance”, and established new administrative units. For this reason, the need to change the name of administrative units was required for the “List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province”. Also the number of discovered immovable properties by the science and research organizations were required to be included in the state protection. In 1998, by the 235th decision of Government, the “List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province” was revised. In accordance with it, 120 immovable properties were selected for the state protection, 233 immovable properties were selected for provincial level protection.

In 2004, the UNESCO World Heritage Committee inscribed Orkhon Valley Cultural Landscape on World Heritage List, including valuable historical and cultural heritages of human history. Orkhon Valley Cultural Landscape has over 100 cultural sites and about 1350 historical and cultural immovable properties, covering area of 121,967 hectares. Orkhon Valley Cultural Landscape has number of immovable properties selected to state and provincial protection.

“The Law for Protection of Historical and Cultural Properties of 1994” has been revised and changed to “the Law for Protection of Cultural Heritage” by the State Great Khural in 2001. As a result of the past 10 years archeological excavations and research works, the number of cultural properties were discovered, and further protection was required for the preservation of those properties. In accordance with it, the “List for Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province” was revised by the government in 2008. On May 14th of 2008, the protection list has been revised by the 175th resolution of Government, and 175 immovable properties were selected as the state protection, 275 immovable properties are under province protection. 15 immovable properties are included in the state protection. 40 immovable properties are under the state protection, 57 immovable properties under province protection. And for the first time, paleontological sites were selected in the protection list of the state and province.

Protection zone of immovable properties: In Paragraph 6 of article 16, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994”, “Government has set up 0.1-3 kilometers of protection zone around the historical and cultural immovable properties, such as remains of ancient cities and settlements, buildings, architecture complexes in order to provide the integrity and safety thereof”. In accordance with this article, setting up protection zones around the immovable properties oversaw their significance on history, culture, science and classification on state protection. By the 241st resolution of Government in 1997, first protection zone was set up around ruins of Kharkhorum city, capital of Mongolian Empire, covering an area of 9.69 square kilometers.

The “Protection law of Historical and Cultural Properties of 1994” revised and changed to “Protection law of Cultural Heritage” by the State Great Khural, in 2001. Paragraphs 6, 7, 8 of article 17, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994” re-entered into “Protection Law of Cultural Heritage” and the article for measurement of surrounding areas was removed

- By the 96th decision of 2001, the protection zones were set up around the Gandantegchinlen Khiid monastery, Monastery Geser, Green Palace of Bogd Khaan, Temple of Chojjin Lama, Temple of Dambadarjaa, Temple of Dashchoilon (Wooden temples), Apartment of Chin Van Khanddorj.
- By the 71st decision of 2002, protection zones were set up around the inscribed monuments for Bilge Khan, memorial complex of Kul Tegin in Khashaat soum of Arkhangai province, ruins of Khar Balgas in Khotont soum of Arkhangai province, Tuvkhun Monastery in Bat- Ulziit soum of Uvurkhangai province, inscriptions monument of Tonyokuk in Bayan soum of Tuv province.
- By the 190th decision of 2003, the protection zones were set up around the complex of

- deer stone called place of Uushgiin Uwur in Burentogtokh soum of Khuvsgul province, ruins of Avarga in Delgerkhaan soum of Khentii province, temple of Manzushir in Tuv province, 2 stone columns of monastery Dari-Ekh in Baynzurkh district of Ulaanbaatar city.
- By the 126th decision of 2004, the protection zones were set up around the ruins of Baruun Khuree in Kharkhorin soum of Uvurkhangai province, remains of 2 temples of Khugnu Tarni in Rashaant soum of Bulgan province
 - By the 70th decision of 2006, protection zones were set up around the inscriptions monument and building remains of Tsogtiin Tsagaan baishin, ruins of Khar Bukh in Dashinchilen soum of Bulgan province
 - By the 123rd decision of 2006, the protection zones were set up around the Orkhon Valley Cultural Landscape as inscribed on World Heritage List, in Arkhangai, Uvurkhangai, Bulgan province
 - By the 135th decision of 2009, the protection zones were set up around the paleontological sites of Ergeliin Zoon in Khatanbulag soum Dornogobi province, complex monuments of Ungut in Altanbulag soum Tuv aimag, complex monuments of Ikh Khushuut in Delgerkhaan soum Khentii province, complex monuments Uglugchiin Kherem, Rashaan Khad, Uzuur Tsohio in Batshireet soum of Khentii province, Baldan Bereeven temple and rock paintings in Umnudelger soum of Khentii province, complex monuments of Dund Jargalant, complex of Tsetsen Khan palaces in Kherlen soum of Khentii province, historic building called “Undur Khorshoo” (recent Fine Art Museum) in Chingeltei District of city Ulaanbaatar, historical building of Central Committee of People’s Party and People’s Government (recent Museum of the History of Ulaanbaatar).

Current status and implementation of works of the protection of historical and cultural immovable properties: Many of our historical and cultural immovable properties have already been destroyed by the human activities and natural and weather decays.

Stone monuments are damaged, cracked, disintegrated by water, wind, chemical substances and bacterial damages, which penetrates pores and capillaries of stone. And natural disaster as a quake, fire, water flood, snow and dust storm has damaged stone monuments. Most of the all immovable properties in Mongolia have damaged by water and component became more porous.

Social factors, such as disrespect to culture, urbanization, economic crisis, sparse population, industrialization, illogical policy, irrational planning, religious issues, wrong conservation and protection, human improper activities are damaging historical and cultural heritages.

Recently, physical damages of immovable properties have increased substantially, due to people’s worship ceremonies. When people worship, they offer and spray milk, butter oil on stones, and wrap them with silk scarf, which have resulted in destruction of these stone monuments.

Today, social behavior has developed disrespect for historical and cultural heritage, people are making illegal excavations to find profits, that also causes destruction and damage for the immovable properties. Also writing letters or drawing images and symbols on ancient rock inscriptions and rock paintings take place.

Since 1940, Mongolia has been organizing number of research and conservation works on protection of immovable properties. In 1944, monastery Erdene Zuu and temple Amarbaysgalant were conserved and restored. In 1960-1961, temple of Choijin Lama, Green Palace of Bogd Khaan were conserved and restored as well.

In 1971, the “Agency of Academy for Research and Scheme Planning of Historical and Cultural Property” was established in the Central Architectural Institute. In 1973, the “Restoration Laboratory of Historical and Cultural Property” was established under the Ministry of Culture. In 1976, both organizations had united under the name of “Conservation and Restoration Laboratory of Historical and Cultural Property”. Since that time until 1995, the organization have conserved many architectural buildings, such as Erdene Zuu, Amarbaysgalant, Gandantegchinlen, Green Palace of Bogd Khaan, temple of Choijin Lama, complex of Tsetsen Khan palaces, monastery of Khachin Lama, apartment of Chin Van Khanddorj, historic buildings in Altanbulag relevant to the People’s Revolution etc. Also local administrations have built fences, put

introduction boards near the immovable properties for protecting them.

Through 1999-2005, the “National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties” was implemented, organizing a systematic conservation and preservations of historical and cultural immovable properties.

Within the framework of this project, Center of Cultural heritage and its conservators and specialists have conserved and preserved immovable properties, made copies and replicas of properties for the storage in the state fund, which are of significant historical and scientific value to Mongolians. And in the framework of this project, number of works have been implemented, such as building fences, conserving monastery and temple buildings, setting up lightening arresters etc.

In 2007, the “National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties” adopted by the 303rd decision of government, for promoting the immovable properties combined with the infrastructure and tourism, and to build capacity of conservators on cultural heritage conservation. The project is planned to be implemented from 2008 till 2015. The work has started. .

Mongolian government is implementing number of works on protection of historical and cultural immovable properties, but it was being destroyed and damaged by the improper activities of people. To stop and prevent this illegal activities on historical and cultural immovable properties, the support of local people is essential.

In the end, we should always remember that our main priority and responsibility is to respect and protect our historical and cultural heritage and pass it on to the future generations.

СҮХБААТАР АЙМГИЙН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Сүхбаатар аймгийн товч танилцуулга. Сүхбаатар аймаг нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт, баруун талаараа Дорноговь аймагтай, хойд талаараа Хэнтий аймагтай, зүүн, зүүн урд, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-той, тус тус хиллэн 82.3 мян.км² газар нутаг эзлэн оршдог. Аймгийн төв нь Баруун-Урт хот, Улаанбаатар хотоос 565 км зайтай.

Сүхбаатар аймгийн газар нутаг нь Ардын хувсгалаас өмнө Сэцэн хан аймагт, 1923 оноос Богд хан уулын аймаг, Хан Хэнтий уулын аймагт тус тус харьяалагдаж байжээ. 1942 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор Жавхлант шарга аймгийг шинээр байгуулж Хэнтий аймгаас 10 сум, Дорнод аймгаас 4 сумын тус тус шилжүүлэн 14 сумыг харьяалуулжээ. УБХ-ын Тэргүүлэгчдийн 1943 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн тогтоолоор их жанжин Д.Сүхбаатарын нэрээр “Сүхбаатар аймаг” гэж нэрлэх шийдвэр гаргасан байна.

Өнөөдөр Сүхбаатар аймаг нь Асгат, Баруун-Урт, Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Наран, Онгон, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан, гэсэн засаг захиргааны 13 сум 67 багтай. Тус аймагт халх, дарьганга ястнууд зонхилсон 55.6 мянган ард иргэд оршин сууж амьдарч байна.

Сүхбаатар аймгийн газар нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвлийн дундаж температур -20° - -24°С, зуны дундаж температур +20° - +24°С, жилд дунджаар 200-250 мм хур тунадас унадаг. Аймгийн нутаг дэвсгэрийн ихэнх хувийг цайвар хүрэн, хүрэн хөрс зонхилсон өндөр талархаг газрын гадарга эзлэнэ. Нутгийн өмнөд хэсгээр Шилийн богд, Зотол хан, Алтан овоо, Сэнжитийн өндөр, Дөш, Гангын Цагаан овоо, Норт гэх мэт 220 гаруй унтарсан галт уулс бий. Сүхбаатар аймгийн нутагт томоохон усан сан бүхий гол мөрөн, нуур байхгүй ч Усан Цагаан, Говийн Цагаан, Ганга гэх мэт нуур, Талбулаг, Арын нуур, Рашаант, Эрээн толгой, Далай булаг, Гашуун, Цагаан булаг зэрэг усны ундрага сайтай булаг, рашаан олон бий.

Сүхбаатар аймгийг 1943 онд Алтан гадас одонгоор шагнажээ.

Сүхбаатар аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж судалсан тухай тойм. 1927 онд Зөвлөлтийн эрдэмтэн В.А.Казакевич Дорнод Монголын нутгаар хэл шинжлэл, угсаатны зүйн судалгаа хийх явцдаа өнөөгийн Дарьганга сумын Алтан овооны орчим 3, Хонгор овоонд 1, Хөргийн хөндийд 6, Гөхөл толгойн өвөрт 2, Онгон сумын Тавантолгойд 2, Наран сумын нутаг Сүмтийн дэлд 2, Хунт ухаад 1 нийт 17 хүн чулуу хөшөөг илрүүлэн олж эрдэм шинжилгээний тодорхойлолт хийж гэрэл зургаар баримжуулжээ. Тэрээр 1930 онд дээрх хүн чулуун хөшөөдийн тухай “Дарьгангын хүн чулуу” гэсэн нэртэй тусгай ном хэвлүүлсэн байна. В.А.Казакевичийн энэхүү судалгаа бол Сүхбаатар аймгийн нутагт эртний судлалын чиглэлээр явуулсан анхдагч ажлын нэг болно.

Үүнээс хойш 1950-аад оныг хүртэл тус аймгийн нутаг дэвсгэр дээр буй дурсгалыг бүртгэх судлах, ажил нэгэн үе зогссон юм. Энэ нь 1930, 1940-өөд оны үеийн зүүн хойд Ази дахь олон улсын цэрэг улс төрийн үйл явцтай шууд холбоотой байв. 1950-иад оны үед Монгол улс түүх, археологийн чиглэлээр өөрийн орны үндэсний боловсон хүчинг бэлтгэж эхэлснээр Монгол орны эртний түүхийн судалгаа илүү өргөн хүрээг хамарч хөгжих үндэс тавигдсан юм.

1957, 1958 оны үед Улсын Төв музейн судалгааны ангийн археологич Д.Наваан Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Устай бургастай, Молцог элс зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн үед холбогдох олдворууд, Өлзийт (хуучнаар) сумын нутагт Төгрөгийн чулуу хэмээх газар хүрэл зэвсгийн үеийн булш, Наран сумын нутгаас “Бичигт цагаан хад” хэмээдэг Манжийн үеийн бичигт дурсгал зэрэг цөөнгүй дурсгалыг шинээр илрүүлэн олж судалгааны эргэлтэнд оруулсан байна. Д.Наваан эдгээр дурсгалын талаар 1960 онд хэвлүүлсэн “Эртний мөр” хэмээх товхимолдоо нийтэлжээ.

Монголын нэрт газар зүйч О.Намнандорж тус аймгийн нутгаар газар зүйн судалгаа хийх явцдаа Өлзийт сумын Налгарын энгэрт хуучны байшингийн туурь, Онгон сумын нутаг Халтарын хошуунд

шороон хэрэм, Дарьганга сумын нутаг Хөрөг хад орчимд эртний булш илрүүлэн олсноо өөрийн бүтээлдээ дурдсан байдаг.

1961 онд БНМАУ-ын ШУА-ын Түүхийн хүрээлэнгээс тус улсын эртний түүхийн газрын зураг зохиох ажлын хүрээнд Сүхбаатар аймагт археологич Н.Сэр-Оджав ахлагчтай хээрийн шинжилгээний ангийг илгээжээ. Энэ анги Сүхбаатар аймгийн нийт 9 сумын нутгаар хайгуул хийж чулуун зэвсгийн үеэс хүрэл, төмөр зэвсгийн үе, эртний улсуудын үед холбогдох олон төрлийн дурсгалуудыг илрүүлэн олсон байна. Археологич Н.Сэр-Оджав Сүхбаатар аймагт ажиллах үеэрээ тус аймгийн нутгаас олдсон хүрэл эдлэлүүдийн талаар хэрэглэгдэхүүн цуглуулж хожим сонирхолтой эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн байдаг.

1960-аад оны дунд үеэс БНМАУ-ын ШУА-ын Түүхийн хүрээлэнгээс Дорнод Монголын нутагт “Гурван голын шинжилгээний анги”-ийг илгээж эхэлсэн юм. Энэ ангийн археологич Х.Пэрлээ, Д.Наваан нар тус бүс нутагт орших хүрэл зэвсгийн дурсгал болох дөрвөлжин булшийг дагнан судлах явцдаа Сүхбаатар аймгийн ихэнх (Мөнххаан, Баянтэрэм, Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян, Эрдэнэцагаан, Халзан, Асгат г.м) сумдаар явж олон тооны дөрвөлжин булш илрүүлэн олж заримыг нь малтан судалжээ. Археологич Д.Наваан 1975 онд өөрийн цуглуулсан дөрвөлжин булшны судалгааны хэрэглэгдэхүүндээ тулгуурлан “Дорнод Монголын хүрлийн үе” хэмээх бүтээл туурвисан нь Монгол орны дорнод хэсгийн хүрэл зэвсгийн үеийн үндсэн төрхийг тодорхойлсон бүтээл болсон юм.

1970 онд МЗТСХЭ-ийн Чулуун зэвсэг судлах анги Монголын зүүн болон говийн аймгуудаар судалгаа хийсний дотор Сүхбаатар аймгийн нутгаас шинэ чулуун зэвсгийн үед холбогдох олон дурсгалт газар олсон байна. Түүнчлэн Сүхбаатар аймгийн хуучин Хонгор сумын Байшинтын хойно орших Их Өргөө уулын бэлээс хуучин чулуун зэвсгийн леваллуа хэлбэрийн болон хоёр талт үлдэц олсон нь тус аймгийн нутагт тухайн үед хүн амьдарч байсныг гэрчлэх биет баримт болсон юм.

1971 онд археологич Д.Наваан Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын төвөөс урагш орших Өлзийтбулаг хэмээх газарт дүгрэг хэлбэртэй хэдэн булш байснаас хэдийг малтан судалж XIII-XIV зууны үед бүтээгдсэн нэг хүн чулуун хөшөө илрүүлэн олсон байна. Тэрээр уг хүн чулуун хөшөөг Улаанбаатар хотод зөөн авчирч Түүхийн хүрээлэнгийн фондоод хадгалжээ.

1980-аад оны эхнээс Сүхбаатар аймгийн нутагт олон байх хүн чулуун хөшөөг археологич Д.Баяр дагнан судалж тус аймгийн нутгаас цөөнгүй хүн чулуун хөшөөг шинээр нэмж олсон байна. Тэрээр эдгээр хөшөөдийн төрх байдал, дүрсэлбэр зэргийг Монголын түүхийн олон сурвалжтай харьцуулан судлаж Монголын Эзэнт гүрэн түүний залгамж Юань гүрний үед холбогдох болохыг тогтоожээ. Мөн тэрээр Дарьганга сумын нутаг Ламт, Хөргийн хөндий, Гөхөл, Онгон сумын шивээт зэрэг 9 газарт Монголын үеийн хөрөг чулуут тахилын овоог анх малтан шинжилсэн юм.

Мөн энэхүү хүн чулуудыг МЗТСХЭ-ийн угсаатны зүйн ангийн бүрэлдэхүүнд ажилласан Л.Л.Викторова, Г.Мэнэс нар судлаж өөрсдийн санал дүгнэлтийг гаргасныг дурьдах нь зүйтэй.

1990-1991 онд ШУА-ын Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан З.Батсайхан, Д.Эрдэнэбаатар нар Сүхбаатар аймгийн зарим сумдаар археологийн хайгуул судалгаа хийсэн бөгөөд уг судалгааны явцад Түвшинширээ сумын нутагт орших Дэлгэрхаан уулын орчимд хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш, Энгэрийн бууцанд Хүннү булш малтан шинжилж олон сонирхолтой олдвор олсон байна.

1990-ээд оноос Монгол Улс өөрчлөлт шинчлэлтийн үрээр дэлхийн олон оронтой археологийн чиглэлээр өргөн хүрээтэй хайгуул, малтлага судалгааны ажил хийж эхэлсэн билээ. Ийм ажлын нэг болох Монгол-Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” хамтарсан археологийн шинжилгээний анги 1992-1993 онд Дарьганга сумын нутагт орших Сүмтийн буюу Гуулин хотын туйрыг малтан судалжээ.

1996-1999 онд Г.Гонгоржав, Г.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний баг “Монгол

нутаг дахь түүх соёлын дурсгал” сэдэвчилсэн лавлах бүтээх ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн нутагт ажиллаж олон тооны дурсгалыг давтан болон шинээр бүртгэж, гэрэл зураг, гар зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан байдаг. Тэдний цуглуулсан үл хөдлөх дурсгалтай холбоотой мэдээ баримт, эх хэрэглэгдэхүүн эдүгээ СӨУНБМС-д хадгалагдаж байна.

1997 оноос эхлэн МУИС-ын Антропологи-Археологийн тэнхим оюутны үйлдвэрлэлийн дадлагаа Дорнод Монгол, тэр дундаа Сүхбаатар аймгийн нутагт голлон явуулах болсноор Монголын түүхийн олон үеийн төрөл бүрийн дурсгалуудыг илрүүлэн олж, залгамж холбоотой шинжлэн судлах ажил хийж байна. 2004 онд археологич Д.Навааны удирдсан хээрийн шинжилгээний анги тус аймгийн Онгон сумын нутаг Тавантолгой хэмээх газарт орших бүлэг булшийг илрүүлэн олж, хэдэн булш малтан судалж онц сонирхолтой олон арван олдворуудыг олсон юм. Үүнээс хойш 2005-2007 онуудад Тавантолгой орчимд хэд хэдэн удаа археологийн хайгуул, малталга судалгааны ажил хийсний үр дүнд дээрх булшнууд нь Дундад эртний Монголын язгууртаны булш болох нь тогтоогдсон байна. Тэрчлэн Мөнххаан сумын Ачаат, Ханан бор, Шархад, Асгат сумын Шаргын уул зэрэг газруудад малталт судалгаа явуулж хуучин чулуун зэвсгийн үеэс дундад эртний үед холбогдох олон арван дурсгал илрүүлжээ.

2008 онд МУИС-ын Антропологи-Археологийн тэнхимийн эрдэмтэн судлаачид Түвшинширээ сумын нутаг Улаан зуухын голд орших эртний оршуулгын газрыг илрүүлэн олж цөөнгүй булшийг малтан судалжээ. Эдгээр булшнаас талийгаачийг түрүүлгэ нь харуулан, зүүн тийш хандуулан тавьсан зан үйл бүхий оршуулга илэрч олдсон нь Сүхбаатар аймгийн нутагт төдийгүй Дорнод Монголын бүс нутгийн хүрэл зэвсгийн үеийн дурсгалын тархалт, угсаа соёлын хамаадлын талаар шинэ хэрэглэгдэхүүн болсон юм.

2010 онд доктор Ц.Төрбатын удирдсан ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги Онгоны Тавантолгой орчимд археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийж олон сонирхолтой олдворыг илрүүлжээ.

2008-2011 онд Монгол-Солонгосын хамтарсан “Дорнод Монгол ба Умардын соёл” төслийн хүрээнд тус аймгийн Дарьганга сумын нутаг Вааран хавцал, Гүн хонхор зэрэг газруудад археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийж хүрлийн үеийн олон тооны булш илрүүлэн олж өдгөө 2 улсын эрдэмтэд уг газруудад археологийн малтлага судалгааны ажил хийж байна.

Монгол оронд археологийн судалгаа үүсч, хөгжсөн 100 гаруй жилийн хугацаанд гадаад дотоодын олон эрдэмтэн судлаачид Монголын баруун, төв, говийн бүс нутагт орших хадны зургийг судлаж цөөнгүй ном бүтээл хэвлүүлсэн байдаг. Харин Дорнод Монголын, тэр дундаа Сүхбаатар аймгийн нутаг дахь хадны зургийн дурсгалыг илрүүлэн олж, судалгааны эргэлтэнд оруулах ажил нэлээд хоцорч байна. Өнөөгийн байдлаар Онгон сумын Будрын чулууны хадны зураг, Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Цагаан элэгийн хадны зургууд хэвлэгдэж судалгааны эргэлтэд оржээ. Сүүлийн үед дурдан буй аймагт хийсэн хайгуул судалгааны ажлын зарим үр дүнгээс харвал урьд өмнө илэрч мэдэгдэн судалгааны эргэлтэд орж байгаагүй цөөнгүй хадны зургийн дурсгал байгаа болох нь мэдэгдээд байна.

Дээр хураангуйлан дурдсан хайгуул, малтлага судалгааны ажлын үр дүн бол Сүхбаатар аймгийн эртний түүхийн дурсгалуудын өнөөгийн байдлыг тодорхойлж буй гол эх сурвалжууд болох юм. Цаашид энэ мэт судалгааны залгамж, халаа болсон олон арван судалгааны ажил хийгдэж Сүхбаатар аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын сан хөмрөгийг баяжуулсан шинэ дурсгалыг илрүүлэн олж тус бүс нутгийн эртний түүхийн талаарх ойлголтыг улам бүр зузаатгах нь эргэлзээгүй юм.

Сүхбаатар аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт. Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх дурсгалаас 1941 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлаас батлан гаргасан “Улсын хамгаалалтад авах дурсгал”-ын дотор нэг ч дурсгал ороогүй байдаг. Харин БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /СнЗ/-ийн 1971 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын жагсаалт”-д Эрдэнэцагаан сумын төвд орших Егүзэрийн хийд, Дарьганга сумын Хөргийн талд орших чулуун

хүн, мөн Дарьганга сумын Хөргийн ширээ хэмээх газарт орших чулуун хүн, аймгийн төвд орших Сүхбаатарын хөшөө, Наран сумын Зүлэгт хэмээх газарт орших Хятад бичигтэй цагаан чулуу гэсэн 5 дурсгалыг орон нутгийн хамгаалалтад байхаар тусгасан байна.

1994 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргасны дараа Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор хуучин СнЗ-ийн 1971 оны 420 дугаар тогтоолыг шинэчлэн “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт” нэрээр баталжээ. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д Сүхбаатар аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтад:

- Дарьганга сумын Хөргийн хөндийд орших хүн чулуунууд
- Дарьганга сумын төвд орших Алтан-Овооны хүн чулуунууд
- Мөнххаан сумын Устай бургастай гэдэг газар орших шинэ чулуун зэвсгийн бууц
- Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд орших Цагаан-Элгийн хадны зураг, Хүннүгийн үеийн 200 ширхэг булшнууд, чулуун хороо, шивээ зэрэг байгууламжууд
- Онгон сумын Шивээт Тавантолгой гэдэг газар орших хүн чулуу ... зэрэг 5 дурсгалыг,

Аймгийн хамгаалалтад:

- Наран сумын Зүлэг гэдэг газар орших хятад бичигтэй Сөдөтийн цагаан чулуу
- Онгон сумын нутагт орших Шивээт, Тавантолгойн хүн чулуунууд
- Эрдэнэцагаан сумын төвд орших Егүзэрийн хийд
- Эрдэнэцагаан сумын нутагт орших Халтарын хийдийн балгас
- Дарьганга сумын нутагт орших Талын агуй
- Дарьганга сумын нутагт орших Хөргийн Ширээнийн хүн чулуунууд
- Дарьганга сумын Ламт гэдэг газар орших хүн чулуунууд
- Дарьганга сумын Сүмт гэдэг газар орших эртний хотын туурь ... зэрэг 8 дурсгалыг тус тус оруулан баталсан байна.

1995-1998 онд УИХ-аас “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-д зарим өөрчлөлт оруулж шинээр аймаг, сум байгуулсан, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад оруулах шаардлагатай дурсгалууд шинээр илэрч олдсон зэрэг шалтгааны улмаас 1994 онд баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэх шаардлага урган гарч ирсэн байна. Энэ шаардлагыг харгалзан Монгол улсын Засгийн газар 1998 оны 235 дугаар тогтоолоор “Улс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтад:

- Дарьганга сумын Хөргийн хөндийд орших хүн чулуунууд
- Дарьганга сумын төвд орших Алтан-овооны хүн чулуунууд
- Мөнххаан сумын Устай бургастай гэдэг газар орших шинэ чулуун зэвсгийн бууц
- Наран сумын Зүлэг гэдэг газар орших Сөдөтийн цагаан чулууны бичээс
- Онгон сумын Тавантолгой гэдэг газар орших 2 ширхэг хүн чулуу.
- Онгон сумын Шивээт гэдэг газар орших хүн чулуунууд
- Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд орших Цагаан-элгийн хадны зураг, Хүннүгийн үеийн 200 ширхэг булшнууд, чулуун хороо, шивээ зэрэг байгууламжууд ... гэсэн 7 дурсгалыг,

Аймгийн хамгаалалтад:

- Дарьганга сумын нутагт орших Хөхөлийн ширээний хүн чулуунууд
- Дарьганга сумын Ламт гэдэг газар орших хүн чулуунууд
- Дарьганга сумын Сүмт гэдэг газар орших эртний хотын туурь

- Онгон сумын Бударын чулуунд орших сүг зурагтай хад
- Эрдэнэцагаан сумын нутагт орших Халтарын хийдийн балгас ... гэсэн 5 дурсгалт газрыг тус тус оруулан баталжээ.

Сүхбаатар аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас дээрх жагсаалтуудад цөөхөн дурсгал хамрагдаж байсан нь нэг талаас судалгаа, эрдэм шинжилгээний ажил бага явагдаж байсан, нөгөө талаас нэгэнт илэрч олдсон дурсгалуудыг олон талаас нь нарийвчлан судалж үнэ цэнэ, ач холбогдлыг нь гаргаж тавих, олон нийтэд сурталчилан таниулах ажил бага байсантай холбоотой ажээ.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг сүүлийн 10 гаруй жилийн туршид шинээр илэрч олдсон олон арван дурсгалаар баяжуулан шинэчлэн баталсан юм. Сүхбаатар аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас уг жагсаалтын улсын хамгаалалтад:

- Дарьганга сумын төвд орших Алтан-Овооны хүн чулуун хөшөөнүүд
- Дарьганга сумын Ламт гэдэг газар орших хүн чулуун хөшөөнүүд
- Дарьганга сумын Хөргийн хөндийн хүн чулуун хөшөөнүүд
- Мөнххаан сумын Устай бургастай гэдэг газар орших шинэ чулуун зэвсгийн үеийн бууц
- Наран сумын Зүлэгт гэдэг газар орших Сөдөтийн цагаан чулууны бичээс
- Онгон сумын Тавантолгой гэдэг газар орших 2 ширхэг хүн чулуун хөшөө, булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал
- Онгон сумын Шивээт гэдэг газар орших хүн чулуун хөшөөнүүд
- Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд орших Цагаан-Элэгийн хадны зураг, Хүннүгийн үеийн 200 гаруй булш, чулуун хороо, шивээ бүхий цогцолбор дурсгал ... зэрэг 8 дурсгалыг,

Аймгийн хамгаалалтад:

- Дарьганга сумын нутагт орших Хөхөлийн ширээний хүн чулуун хөшөөнүүд
- Дарьганга сумын Сүмт гэдэг газар орших эртний хотын туурь
- Онгон сумын Бударын чулуу гэдэг газар орших хадны зураг
- Эрдэнэцагаан сумын нутагт орших Халтарын хийдийн балгас... гэсэн 4 дурсгалыг тус тус хамгаалалтад авчээ.

Дээр дурдсан 3 удаагийн хамгаалалтын жагсаалтад орсон Сүхбаатар аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал тооны хувьд нэг их өөрчлөгдөөгүй нь тус бүс нутагт явуулсан бүртгэл, судалгаа дутмаг, илрүүлсэн дурсгалын үнэ цэнэ ач холбогдлыг тодруулахаар судалгааны ажил бага хийгдсэнтэй холбоотой ажээ.

Сүүлийн жилүүдэд түүх, археологи, угсаатны зүйн судалгааг мэргэжлийн олон эрдэм шинжилгээний байгууллагууд бие даан болон гадаадын өндөр хөгжилтэй орнуудын туслалцаа дэмжлэгтэйгээр Монгол орны бүх хэсэгт явуулж олон дурсгалуудыг шинээр илрүүлж, судалж шинжсээр байна. Энэ ажлын үр дүнд Сүхбаатар аймгийн нутгаас үнэ цэнэ, ач холбогдол нь улс, бүс нутгийн хэмжээнд үнэлэгдэхээр олон арван дурсгал шинээр олдож төрийн хамгаалалтад орох нь эргэлзээгүй юм.

Манай улс хээр хөдөө ил задгай газарт олон зуун жилийн нүүрийг үзэж эвдэрч гэмтэж буй эртний дурсгалуудыг байгаль, нийгмийн сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр хэрэгжүүлэх зорилгоор 1998 оноос эхлэн Засгийн газраас тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Монгол улсын Засгийн газрын 1998 оны 51 дүгээр тогтоолоор батлагдан гарсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийн 3,13-д Сүхбаатар аймгийн Наран сумын нутагт орших Сөдөтийн цагаан чулууг хашаа барьж хамгаалахаар, 5.21-24-д Онгон сумын нутагт орших Шивээт толгойн хүн чулуун хөшөөд, Тавантолгойн хүн чудуун хөшөөд, Наран сумын нутагт орших Сөдөтийн цагаан чулууны бичээс, Дарьганга сумын нутагт

орших Ламтын хүн чулуун хөшөөдөөс хэв, хуулбар авч Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалахаар, 6.4, 6.5-д Онгон сумын нутагт орших Тавантолгойн болон Шивээт толгойн хүн чулуун хөшөөдийн эх хувийг улс, орон нутгийн музейд татан авч хадгалах, орон нь хуулбар эх байрлуулахаар, 7.14-17-д Дарьганга сумын нутагт орших Хөргийн хөндийн хүн чулуунууд, Хөхлийн ширээнд орших хүн чулуунууд, Алтан овооны хүн чулуунууд, Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын дурсгалуудыг түүх, соёлын дурсгалт газар болгон хамгаалалтад авахаар тус тус төлөвлөж оруулсан байна. Эдгээр ажлуудын ихэнхийг холбогдох байгууллагууд бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зарим нэг ажлын төлөвлөлт буруугаас хийгдэлгүй хоцорсон байдаг.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөрийг олон агуулгаар баяжуулж, дэс дараатай үргэлжлүүлэхийн тулд Монгол улсын Засгийн газар 2007 оны 303 дугаар тогтоолоор шинээр боловсруулсан хөтөлбөрийг батлан гаргасан юм. Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа түүх, соёл, шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой дурсгалуудаас нэн тэргүүнд авран хамгаалах шаардлагатай дурсгалуудыг сонгон оруулжээ. Энэ хөтөлбөрт Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх дурсгалаас цөөнгүй дурсгалыг хамгаалахаар тусгажээ. Тухайлбал хөтөлбөрийн 5.4.1-д Онгон сумын нутагт орших Тавантолгойн хүн чулуун хөшөөдийг унаган газраас нь зөөж Улаабаатар хотод хадгалахаар, 5.6.4-6-д Дарьганга сумын нутагт орших Алтан овооны хүн чулуун хөшөөд, Ламтын хүн чулуун хөшөөд, Хөргийн хөндийн хүн чулуун хөшөөдийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож дэргэд нь танилцуулга самбар байрлуулахаар тус тус төлөвлөжээ. Дээр дурдсан ажлуудыг БСШУЯ-ны харьяа Соёлын өвийн төвийн сэргээн засварлагчид 2008, 2009 онуудад бүрэн хэрэгжүүлж дуусгасан байна.

2008 оны үл хөдлөх дурсгалын тооллого, бүртгэлийн ажлын тухай: Соёлын өвийн төвийн мэргэжилтэн судлаачдаас бүрдсэн хээрийн шинжилгээний баг Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлынхаа хүрээнд 2008 оны 8 дугаар сарын 30-наас 9 дүгээр сарын 29-нийг хүртэлх хугацаанд Сүхбаатар аймгийн 13 сумын нутагт ажилласан юм. Бид тус аймгийн нутагт нийт 4320 км зам туулан 84 дурсгалт газрын 800 орчим нэгж ширхэг дурсгалыг давтан болон шинээр олж бүртгэн, тэдгээрийг 5018 ширхэг дижитал гэрэл зураг, 56 гар зураг, 231 минутын дүрс бичлэгээр тус тус баримтжуулжээ.

Бид Сүхбаатар аймгийн нутагт ажиллахдаа сум орон нутгийн холбогдох хүмүүстэй хамтран ажиллах замаар бүртгэл мэдээлэл, хадгалалт хамгаалалт, хяналт шалгалтын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зарим орон нутгийг судлах танхим, музейд неолитын үед холбогдох чулуун зэвсгийн цөөнгүй дээжийг хүлээлгэн өгч сан хөмрөгийг нь баяжуулсан юм.

Сүхбаатар аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлыг хөдөө орон нутагт зохион байгуулахад жолоочоор ажилласан Б.Эрдэнэмохн болон тухай бүр туслан дэмжиж байсан сумдын ИТХ, ЗДТГ, Соёлын төвийн хамт олон, малчид, ард иргэддээ баярласан талархаснаа илэрхийлье.

HISTORICAL AND CULTURAL IMMOVABLE PROPERTIES IN SUKHBAATAR PROVINCE

Introduction of Sukhbaatar province. Sukhbaatar province is located in southeastern part of Mongolia, bordering with Dornogovi province to the west, with Khentii province to the north, with the Inner Mongolia Autonomous Region of People's Republic of China to the east, south-east and south, covering 82.3 thousand sq kms. Baruun-urt is capital of Sukhbaatar, located 565 kms from Ulaanbaatar city.

Prior to the People's Revolution, the territory of Sukhbaatar province was a part of Setsen khan aimag (province). Since 1923, the province was united to the Bogd Khan Mountain and Khan Khentii Mountain provinces. By the decision of Presidium of State Baga Khural of 1942, the Javkhlant sharga province was established with 14 soums, transferring 10 soums of Khentii province and 4 soums of Dornod provinces to it. According to the decision of Presidium of State Baga Khural of April 20 of 1945, the province was called "Sukhbaatar province" after the commander in chief of the Revolutionary army, Sukhbaatar D.

Today Sukhbaatar province has 67 baghs (smallest administrative unit), 13 soums (small administrative unit) Asgat, Baruun-urt, Buyandelger, Dariganga, Munkhkhaan, Naran, Ongon, Sukhbaatar, Tuvshinshiree, Tumentsogt, Uulbayan, Khalzan and Erdenetsagaan. It has a population of 55.6 thousand, having predominance of khalkh and dariganga ethnic groups.

Sukhbaatar province has an extreme continental climate with long, cold winters and short summers. The average winter temperature falls between -20°C and -24°C. In summer it rises between +20°C and +24°C. The average rainfall can be between 200mm and 250mm. Most of the territory is steppe, consisting of brown, light brown types of soil. About 220 dormant volcanos are located in south of territory, such as Shiliin Bogd, Zotol khan, Altan ovoo, Senjitiin undur, Dush, Gangyn Tsagaan ovoo and Nort etc. However, Sukhbaatar province hasn't biggest rivers and lakes, it some lakes Usan tsagaan, Goviin tsagaan, Ganga and mineral springs Tal bulag, Aryn nuur, Rashaant, Ereen tolgoi, Dalai bulag, Gashuun and Tsagaan bulag etc.

In 1943, Sukhbaatar province was awarded by Order of the Polar Star.

Research and registration work on immovable properties of Sukhbaatar province. In 1927, Russian scientist V.A.Kazakeivech while having linguistic and ethnological survey in territory of Dornod Mongol (eastern Mongolia) discovered 17 man stones, 3 of them in Altan ovoo, 1 in Khongor ovoo, 6 in valley of Khurug, 2 in Gukhul tolgoi of Dariganga soum, 2 in Tavantolgoi of Ongon soum and 2 in Sumt and 1 in Khunt ukhaa of Naran soum. He has made their research description and documented by photograph. After in 1930, he has published the book "Man stone of Dariganga". This survey carried out by V.A Kazakeivech was first archeological survey in territory of Sukhbaatar province.

Until 1950's, the research and registration of work of the historical and cultural properties of Sukhbaatar province has disrupted relevant with international military-political strategy in northeastern Asia in 1930's and 1940's. Mongolia has trained archeological examiners in 1950's and since then archeological study has developed in Mongolia widely.

In 1957 and 1958, archeologist D.Navaan member of survey team of State central museum has newly discovered and examined Neolithic findings from place called Ustai burgastai and Moltsoг els (Moltsoг sand) in Munkkhaan soum, Bronze Age grave at place called Tugrugiiin chuluu in Ulziit soum (as before), "Bichigt tsagaan khad" related to Manchu period in territory of Naran soum etc. He included about this immovable properties in his published book "Ancient track" in 1960.

Mongolian most respected geographer, researcher O.Namnandorj has discovered the ruin of old building at slope of Nalgar in Ulziit soum, earthen wall in Khaltaryn khoshuu in Ongon soum and ancient grave of Khurug khad in Dariganga soum and included in his published book.

In 1961, in the framework of creation of ancient history map, the survey team under the guidance of N.Ser-odjav has worked in territory of Sukhbaatar province by the consent of Institute of History, Mongolian Academy Sciences of People's Republic Mongolia. This survey team has worked in 9 soum's territory of Sukhbaatar province and discovered numerous findings related to Stone Age, Bronze Age,

Iron Age and ancient state periods. Later, archeologist N.Ser-odjav has wrote interesting research article on Bronze findings discovered from Sukhbaatar province.

Mid of 1960's, the survey team called "Gurvan gol" has worked in territory of Dornod Mongol by the consent of Institute of History, Mongolian Academy Sciences of People's Republic Mongolia. Members of survey team, archeologist D.Navaan and Kh.Perlee have examined the square tombs of Sukhbaatar province (almost all soums including Munkhkhaan, Bayanterem, Bayandelger, Tuvshinshiree, Uulbayan, Erdenetsagaan, Khalzan, Asgat etc) and made excavation on some of them. Archeologist D.Navaan examined the square tombs of Sukhbaatar Province, related to the Bronze Age and he published a book called "Bronze Age of Eastern region of Mongolia" using his research and examination materials in 1975.

In 1970, survey team for stone tools of Mongolian and Soviet historical and cultural joint expedition has carried out survey in eastern region of Mongolia and discovered numerous Neolithic sites in territory of Sukhbaatar province. Also discovered *Levallois* or two sided remains from foot of mountain Ikh Urguu in Baishint of Khongor soum (as before) in Sukhbaatar province and it is physical evidence of ancient human was lived at territory of province.

In 1971, archeologist D.Navaan has examined numerous round shaped graves at place called Ulziit Bulag south of Bayandelger soum's center and made excavation on some of them. As a result of excavation he has discovered one man stone created by XIII-XIV centuries and he has transferred this stone to the storage of Institute of History.

In 1980's, archeologist D.Bayar has examined the man stones at territory of Sukhbaatar province and discovered several man stones newly. He has examined figure and depiction of these man stones comparably with historical resources of Mongolia and have determined that, it related with Mongol Empire and its descendant Yuan dynasty. Also he has examined and excavated the sacrificial stone structure with man stone related to Mongol period at 9 sites including Lamt, Khurgiin Khundii, Gukhul in Dariganga soum and Shiveet in Ongon soum etc.

Also, L.L Victorova and G.Menes member of survey team for stone tools of Mongolian and Soviet historical and cultural joint expedition have examined and determined these man stones.

In 1990 and 1991, archeologist Z.Batsaikhan, D.Erdenebaatar made archeological examination and excavation in some soums of Sukhbaatar province and discovered interesting findings from square grave related to Bronze Age around of mountain Delgerkhaan in Tuvshinshiree soum and Khunnu grave at settlement Enger.

In 1990's, Mongolia has been collaborating with world countries on archeological studies and have started wide archeological examination and excavation. 1992-1993, one of these excavations has carried out by Mongolian and Korean joint survey team "Dornod Mongol" and team has excavated ruin of city Guulin or Sumt at territory of Dariganga soum.

In 1996-1999, in the framework of the creation of guidebook "Historical and Cultural Properties of Mongolia" the research team including G.Gongorjav and G.Enkhbat worked in Sukhbaatar province, and have discovered and registered number of immovable properties and documented them by hand drawings, video recordings and photos. Today these research materials are kept in a registration and information state fund of cultural heritage.

Since 1997, Department of Archeology and Anthropology of National University of Mongolia has organized the student's practical training in Dornod Mongol (Eastern Mongolia), especially in Sukhbaatar province. As a result of this practical training various kind of historical and cultural properties related to historical periods of Mongolia have discovered and examination work carried out. In 2004, team for field survey under the guidance of archeologist D.Navaan, have discovered and excavated group of graves at place called Tavantolgoi in Ongon soum and found numerous interesting findings. Then in 2005-2007, several times archeological examination and excavations have carried out around of Tavantolgoi and it has determined as graves of Mongol nobles. Also, carried out examinations and excavations at place called Achaat, Khanan bor, Sharkhad in Munkhkhaan soum and mountain Sharga in Asgat soum, and discovered numerous findings from Paleolithic period to Mongol's period.

In 2008, examiners and researchers of Department of Archeology and Anthropology of National University of Mongolia have discovered funeral site at place called Ulaan Zuukhyn gol in Tuvshinshiree soum and made excavations on some of them.

Some specific features in funeral practices involve placing the dead human bodies in prone position alternately than placing them directed to the east is became new research materials on properties of Bronze Age in Sukhbaatar province and but also Dornod Mongol region (Eastern Mongolia).

In 2010, survey team of Institute of Archeology, Mongolian Academy of Sciences under the guidance of Ts.Turbat has carried out the archeological examination and excavation in Tavantolgoi at Ongon soum and discovered nnumerous interesting findings.

In 2008-2011, in the framework Mongolian and Korean joint project "Eastern Mongolia and Northern Culture", survey team has made archeological excavation and excavation at place called Vaaran khavtsal and Gun khonkhor in Dariganga soum of Sukhbaatar Province and discovered numerous graves related to Bronze Age. Today 2 foreign countries examiners and researchers are working in these sites.

For 100 years of historic development of science of archeology in Mongolia, foreign and domestic numerous examiners and scholars have examined the petroglyphs at western, central, gobi region of Mongolia and published several books. The research and examination of petroglyphs of Dornod Mongol especially the Sukhbaatar province has backward. Today the photos of petroglyph of Budar stone in Ongon soum, petroglyph of Tsagaan eleg at mountain Delgerkhaan in Tuvshinshiree soum have published and used in the survey and examinations. As a result of recent year's survey, several petroglyphs were discovered in Sukhbaatar province.

Above mentioned brief information are main survey resources of historical and cultural immovable properties of Sukhbaatar province. It is no doubt that numerous archeological examination and excavations would be carried out further related to enrich the storage of historical and cultural immovable properties of Sukhbaatar province.

Protection and preservation of historical and cultural immovable properties of Sukhbaatar province: None of the immovable properties of Sukhbaatar province were included in the "State protection of immovable properties" adopted by the 79th conference decision of Presidium of State Baga Khural in 1941. Following five immovable properties of Sukhbaatar province included in the local protection of "List for Protection of Historical and Cultural Properties of People's Republic Mongolia" adopted by the 420th decision of Council of Ministers of Mongolia in 1971.

- Temple of Eguzer at the center of Erdenetsagaan soum
- A man stone at valley Khurug in Dariganga soum
- A man stone at place called Khurgiin shiree in Dariganga soum
- Statue of Sukhbaatar located at center of Province
- White stone with Chinese inscriptions at place called Zuleg in Naran soum;

In 1994, after the adaptation of "Law on Protection of Historical and Cultural Properties" by State Great Khural, previous 420th decision of the Council of Ministers of 1970 was amended by the 233rd decision of government and adopted "List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province". At the third appendix of the 233rd decision, 5 immovable properties of Sukhbaatar Province were included in the state protection according to the "List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State and Province". Including:

- Stone statues at valley Khurug in Dariganga soum
- Man stones of Altan ovoo at the center of Dariganga soum
- Neolithic settlement located at place called Ustai burgastai in Munkhkhaan soum
- Petroglyph of Tsagaan eleg, over 200 Khunnu graves, stone wall and stone arrangement at mountain Delgerkhaan in Tuvshinshiree soum
- A man stone at place called Shivee tavan tolgoi in Ongon soum,

The following 8 immovable properties were selected for the provincial protection:

- White stone Sudut with Chinese inscriptions at place called Zuleg in Naran soum
- Man stones of Shiveet and Tavan tolgoi in Ongon soum
- Temple of Eguzer at center of Erdenetsagaan soum
- Ruin of temple Khaltar located in territory of Erdenetsagaan soum
- Cave of Tal in Dariganga soum
- Man stones of Khorgyn Shiree in Dariganga soum
- Man stones at place called Lamt in Dariganga soum
- Ruin of ancient city at place called Sumt in Dariganga soum,

Through, 1995-1998, an amendment was required for the "List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State and Province" adopted by 1994, for the following reasons such as "Law of Mongolia on Administrative and Territorial Units and Their Governance" was revised and established new administrative units, and number of immovable properties were discovered by the archeological excavations needed to be included in the state protection list. In 1998, for this required "List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State and Province" was amended by 235th decision of government.

The following 7 immovable properties of Sukhbaatar province were selected for state protection:

- Man stones at valley Khurug in Dariganga soum
- Man stones of Altan ovoo at the center of Dariganga soum
- Neolithic settlement located at place called Ustai burgastai in Munkhkhaan soum
- White stone Sudut with inscriptions at place called Zuleg in Naran soum
- Two man stones at place called Tavantolgoi in Ongon soum
- Man stones at place called Shiveet in Ongon soum
- Petroglyph of Tsagaan eleg, over 200 Khunnu graves, stone wall and stone arrangement at mountain Delgerkhaan in Tuvshinshiree soum

The following 5 immovable properties were selected for provincial protection:

- Man stones at place called Khukhuliin shiree in Dariganga soum
- Man stones at place called Lamt in Dariganga soum
- Ruin of ancient city at place called Sumt in Dariganga soum
- Petroglyphs on stone Budar in Ongon soum
- Ruin of temple Khaltar located in territory of Erdenetsagaan soum,

From one hand, the inclusion of few immovable properties of Sukhbaatar Province in the above List was caused by the poor research work was being done in the territory of the province, and from the other hand, the comprehensive scientific research on already discovered properties never been done and having no promotion for the public.

In 2008, "List for protection of historical and cultural immovable Properties of state, provincial, Ulaanbaatar city" was amended by 175th decision of government and it was enriched by the number of immovable properties which were discovered in last 10 years research.

The following 8 immovable properties of Sukhbaatar Province were selected for state protection:

- Man stones of Altan ovoo at the center of Dariganga soum
- Man stones at place called Lamt in Dariganga soum
- Man stones at valley Khurug in Dariganga soum
- Neolithic settlement located at place called Ustai burgastai in Munkhkhaan soum
- White stone Sudut with inscriptions at place called Zuleg in Naran soum
- Complex monument with two man stones, graves and tumulus at place called Tavan tolgoi in Ongon soum
- Man stones at place called Shiveet in Ongon soum
- Petroglyph of Tsagaan eleg, over 200 Khunnu graves, stone wall and stone arrangement at mountain Delgerkhaan in Tuvshinshiree soum,

The following 4 immovable properties of Sukhbaatar province were selected for provincial protection:

- Man stones at place called Khukhuliin shiree in Dariganga soum

- Ruin of ancient city at place called Sumt in Dariganga soum
- Petroglyphs on stone Budar in Ongon soum
- Ruin of temple Khatlar located in territory of Erdenetsagaan soum,

However immovable properties of Sukhbaatar province included in the above three protection list, its number was not increased. It is relevant with lack of survey, examination and registration of immovable properties.

Recently, the research and examination of history, archeology and ethnology is being promoted by the support of foreign countries, relevant with this research and examination work of immovable properties of Sukhbaatar Province is being extended. It is no doubt that many historical and cultural heritages of valuable immovable properties would be found and preserved further.

Since 1998, Mongolia has implemented the special project for the immovable properties at field sites, aiming to prevent and protect them from the negative impacts of natural and social factors.

